

ПЕРУГИЙН КОРТЕКС ӨРНӨ, ДОРНЫН АНАГААХ УХААНЫ ИНТЕГРАЦИЙГ ЭХЛҮҮЛСЭН НЬ

Б.Гэрэлмаа¹, Ш.Болд¹, Б.Дагданбазар²

¹ЭЗШУИС, ²“Ач” АУИС,

И-мэйл: gerele_0602@yahoo.com

THE INTEGRATION OF THE EASTERN AND WESTERN MEDICINE THROUGH THE PERUVIAN CORTEX

Gerelmaa B¹, Bold Sh¹, Dagdanbazar B²

¹Mongolian University of Pharmaceutical Sciences, ²Ach Medical University

Email: gerele_0602@yahoo.com

Abstract

Introduction: This work includes information on diseases and important rich experiences of medicine. However, the initial work has not been clearly stated in the versions. The reason and purpose to do our research is that the work has not been introduced to the practice.

Methods: The document analysis, logical argumentation, comparative historical research and hermeneutics have been utilized in the research.

Results: 1. Five years were spent to print the four original copies of the work by the help of scholars and Jesuit fathers. An original copy of the work is kept in the Royal Academy of Sciences in Paris and another original copy is in the Royal Library in Copenhagen.

2. The work illustrates anatomy, diagnosis of diseases, medicine and treatments. It is interesting that the story of the work is stated in the first topic.

3. By comparing Mongolian versions, the topic on anatomy was absent in the version of Zodovjav's translation. Different time and different word choice of translations influenced dissimilar versions in Mongolian.

Conclusion: 1. This work was written in the first two decades of the 18th century by the order of Emperor K'ang Hsi of Manchu.

2. This work is the medicine book that connects Eastern medicine to Western.

3. Even though translations of word are different in the versions, the contents are alike.

Key words: Manchu anatomy, mandated, Emperor K'ang Hsi, Jesuit fathers.

Судалгааны ажлын үндэслэл: Монголчуудын ахуй амьдралын онцлог, дадал хэвшил нь эрүүл амьдрах ухааны бие даасан тогтолцоог бүтээн бий болгожээ. Энэхүү тогтолцоо нь хөгжлийн явцдаа соёлын томоохон хэсэг болж, бусад орны анагаах ухааны мэдлэгээр баяжигдсаар ирсэн байна¹. Жишээлбэл: Монгол анагаах ухааны биеийн бүтэц зүйн хөгжилд нөлөө үзүүлсэн “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” хэмээх анагаах ухааны хосгүй ховор бүтээл билээ². Уг бүтээлийг манай анагаах ухааны эрдэмтэд нарийвчлан судлаагүй байсныг АШУ-ы доктор, профессор Б.Дагданбазар дээд, доод боть зохиолыг бусад эх зохиолуудтай харьцуулан судалж Монголын

анагаах ухааны бие бүтэц зүй судлал-туршин шинжлэл, эмнэл зүйн уламжлал, шинэчлэлийн онол арга зүйн үндсийг нээн илрүүлэх, зарим шинэ мэдээллээр баяжуулах талаар томоохон хувь нэмрээ оруулжээ³.


Энэхүү зохиолыг тэрхэн үедээ латин хэлнээс монгол хэлээр орчуулсан анагаах ухааны зохиол хэмээн дурдсан боловч, түүнийг нарийвчлан судлах явцад ганц латин бус Дорно дахины төвөд, санскрит, хятад, монгол хэлний үг өгүүлэмж, эртний эрдэмтэд болон улс, газар орны нэр тааралдаж буй нь гүнзгийрүүлэн судлах шаардлагатай илтгэнэ⁴. Иймд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийн уг гарал, түүх, бүтээгдсэн он цаг, зарим агуулгыг

харьцуулан судлах, эх сурвалж, зарим түүхэн баримтуудыг судалгааны эргэлтэд оруулахаар энэхүү сэдвийг сонгон авсан.

Бидний судалгааны ажлын зорилго “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийн түүх, эх сурвалжийг тодруулахад оршино.

Материал арга зүй: Бид судалгаандаа “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг. Ринчен Б, эрх. ШУАХҮйлдвэр, 1971”, “Dergici toktobuha ge ti ciovon lu bithe. Манж хэлээр бичсэн гар бичмэл хуулбар ном”, “The Manchu anatomy and its historical origin. John B. deC.M.Saunders and Francis R.Lee, trans. Taiwan, 1981”, “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг. Содномдаржаа, хэв Урлах эрдэм, 2000”, “Зарлигаар тогтоосон Хэ-Ти-Чиуван-Лу бичиг. Балдан-Очир, хян. ӨМШУТМХ, 1986” гэсэн нийт 5 материалыг эх бичиг, сурвалж бичгийн судлал, түүхэн харьцуулалтын болон герменевтик аргыг ашиглан судлав.

Үр дүн: 1901 онд Хятадад гарсан Боксерын бослогын дараахан Питер Арт Кирулф хэмээх Данийн эртний эдлэл цуглуулагч болон нэгэн хятад ажилчин хоёрын хооронд бага хэмжээний наймаа хийгджээ. Тэдний наймаа нь нийт 90 хуудас, анатомийн зургаар дүрсэлсэн (Picture 1) манж хэлээр бичсэн гар бичмэл ном байлаа.



Picture 1. Manchu anatomy

Номыг Копенгаген хот руу илгээсэн бөгөөд уг ном Дани улсын эмч, физик эмчилгээг санаачлагч Абрахам Клод-Хансены анхаарлыг татсан байна. Учир нь тэрбээр XVII зууны

анатомийн бүтээлийг тусгайлан сонирхон судалж байв. Удалгүй Абрахам Клод-Хансен гар бичмэлийг XVII зууны сүүлч, XVIII зууны эхэн үед Манжийн хааны ордонд айлчилж байсан Францын Есүсийн нийгэмлэгийн элч нарын бүтээл гэж тодорхойлжээ. Копенгаген, Парисын хуулбарыг хооронд нь харьцуулахад Парисын гар бичмэл нь жижиг форматтай байснаас бусад талаараа Копенгагений гар бичмэлтэй яг адилхан болох нь тогтоогджээ. Судалгааны ажлын уг үр дүнгээ Клод-Хансен 1906 онд Копенгагены Биологийн Нийгэмлэгт танилцуулсан бөгөөд гар бичмэлийг өөрийн судалгааны ажлын 3 үр дүнгийн хамт Хааны Номын Сангийн Дорно Дахины цуглуулгад хандивлажээ.


Манжийн эзэн хаан 1692 онд 40 настай байхдаа хумхаа бууу чичрэг өвчнөөр өвдсөн байна. Хаан хэдийгээр өөрийн ордны эмч нарт үзүүлж эм уусан ч сайжралыг олоогүй ажээ. Хааны өвдсөн нь барууны анагаах ухааныг ойлгуулах, бишрэлийг төрүүлэх, дэлгэрүүлэх чухал мөч завшаан болжээ. Энэхүү үйл явдлыг нүдээр харсан хүний өгсөн мэдээллийг Фонтаней албан мэдээндээ тэмдэглэн үлдээснийг сонирхъё. Эцэг Висделоу бид хоёр Перугийн кортекс (мөн барк гэдэг)-оос (Picture 2) нэг фунтийг ордонд авч ирсэн... Бид үүнийг чичрэг өвчний эсрэг Европт хэрэглэдэг хамгийн сайн эм хэмээн зарлан хаанд өргөв. Дараа өдөр нь чичрэг өвчнөөр өвдсөн 3 хүнд кортекс уулгасан. Эхнийх нь эм уухад ямар нэгэн хүндрэл гараагүй үргэлжлүүлэн ууж дууссан. Харин хоёр дахь нь уусны дараа өдөр нь татсан, гурав дахь хүн ууссаар өвчин нь илааршив. Гурван өвчтөнийг ордондоо байлгаж, тусгайлан томилогдсон хүн хянаж, кортексийг уусны дараа бүгд эдгэрчээ. Өөр эх сурвалжид хаан өөрийн 3 агьд уг эмийн уулгасны дараа хаан өөрөө уусан⁵ гэж тэмдэглэсэн байдаг.

Барууны анагаах ухаанаас үр шимийг нь



Picture 2. Peruvian cortex (*Cinchona cordifolia*)

хүртсэн Энх-Амгалан хаан гадаадын шинжлэх ухааныг ихэд сонирхож байв. Тэрээр эцэг Бүветийг анатомийн тухай анагаах ухааны бүтээл бэлтгэхийг тушаажээ. Бүвет удалгүй Франц руу явсан тул анатоми хичээл заах ажил зогсов. 1698 онд Хятадад ирсэн Доминик Пареннин (1665-1741) хэмээх өөр нэг элч уг ажлыг үргэлжлүүлэн дуусгасан



Picture 3. Pierre Dionis

Анатомийн номыг таван жил бичсэн бөгөөд энэ хугацаанд эзэн хаан өөрийн гурван хятадач, хоёр бичээч, хоёр зураач гарган өгч туслуулав. Уг бүтээл дууссаны дараа эзэн хаан хэвлэх зөвшөөрөл өгөхөөс татгалзав. Учир нь энэ бүтээл хойшдын үл мэдэх хүмүүсийн бодол оюунд үлдээх энгийн нэг ном биш хэмээн үзжээ. Гар бичмэлийг унших эрхийг хэдхэн хүмүүст олгон, тэдэнд номыг авч гарах, эсвэл тэмдэглэл хөтлөх зөвшөөрөл олгохгүй байв. Нийт гурван хуулбарыг гараар бичиж, Бээжин хотод нэг, нийслэлээс гаднах цэнгэлдэх ордонд нэг, гурав дахийг нь Манжийн өвөг дээдсийн нутаг Жехолд тус тус хадгалагджээ. Харин Пареннин нэгэн тусгай хуулбарыг хийн өөрийн гишүүн байсан

байна. Тэрбээр бүтээлдээ Пиер Дионисийн бичсэн тэр үедээ хамгийн нарийн, тодорхой бичигдсэн гэгддэг, Европт анатомийн стандарт бүтээлүүдийн нэг байсан номыг (Picture 3) сонгон авчээ. Харин жишээ зургийн хувьд Данийн Томас Бартолинийн номыг (Picture 4) илүүд үзжээ.



Picture 4. Thomas Bartholin
L Anatomie de l'Homme Anatomie
ex omnium veterum recentiorumque
observationibus

Парис дахь Шинжлэх Ухааны Академид илгээв. Энэ талаар мөн Калифорнийн их сургуулийн доктор, профессор М.Саундерс “Пареннин 1723 оны 5 дугаар сарын 1-ий өдрийн Бээжингээс илгээсэн захианы хамт номын дөрөв дэх хувийг эргэлзэх зүйлгүйгээр Парис дахь Шинжлэх Ухааны Академид илгээсэн” гэсэн байна. 1933 онд хэвлэгдсэн Бээжин дэх хуучин Ордны номын санд Манж номын катологид анатомийн ямар нэгэн зохиол бүртгэгдээгүй ажээ. Тиймээс Парис, Копенгагены гар бичмэлүүд нь Паренниний хөдөлмөрийн цорын ганц нотолгоо байж болох юм⁶.

Хэлцэмж: “Анагаах ухааны дөрвөн үндэс” судрын “Язгуур” үндсийн “Өгүүлэхийн суурийн

бүлэг”-т Оточ Манал бурхан анагаах ухааныг “тэнгэрийн нөхөд”, “аршийн нөхөд”, “гадаадын нөхөд”, “дотоодын нөхөд” нарт заан “Тэр цагт, тэр үед багш бээр номлосны нэг үгийг дөрвөн зүйлийн нөхдүүд тус тус өөр өөрийн багшийн ёсоор ухаарсан болой” хэмээн өгүүлэмж гардаг.

“Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийн “Хүний өвчин эмгэгийн уг шалтгааныг эхлэн өгүүлэх нь” хэсэгт: “*Ге-Рви-Ший-Еэ* *ᠭᠡ ᠷᠪᠢ ᠰᠢᠢ ᠡ* улсын *Эс-хиуй-лав* *ᠡᠰ ᠬᠢᠭᠢᠯᠠᠭ* нэртийн, арван наймдугаар үеийн ач, *Эй-Бо-Гве-Ре-Дис* *ᠡᠢ ᠪᠣ ᠭᠡ ᠷᠡ ᠳᠢᠰ* -ийн үед мөнхүү түүний, элэнцээс уламжилсаныг өөр өөр ялгаж тулгуур бичиг зохиогоод, сурагч ардад, өөр өөр зааж сургаснаар, эмчлэн засах ёсоор, ертөнцөд тодорч, ... дээрээс тогтоосон бичиг үүнээс үүсвэй”⁷ хэмээн тэмдэглэжээ. Тэгвэл грек сурвалж Гипократын хуучин тангаргаас харахад “Би Апполо болон эмчийн бурхан Эскулапынхан, оройн дээд охин тэнгэр бурхны нэрийг барьж ...тангараглая” гэсэн байдаг нь гарал үүслийн хувьд Эскулапаар холбогдсон нэг үндэстэй гэж үзэхэд хүргэлээ. Мөн Зевсийн хүү Апполо, түүний хүү Эскулапыг дээр дурдсан “Анагаах ухааны дөрвөн үндэс” сударт гардагчлан “гадаадын нөхөд”-д багтах “Махадэва”-д хамаарна гэж үзэж байна. Учир нь санскрит хэлээр “Махадэва” гэдэг үг нь: төвөд, монголоор “Ванчүг”, хинди шашинд “Шива”⁸, өрнө дахинд Зевс бурхныг тодорхойлсон үг билээ.

Дүгнэлт: Уг бүтээлийг анх Чин улсын Энх-Амгалан хааны зарлигаар XVIII зууны 10-аад оны үед манж хэлээр ердөө 4 гар бичмэл хувийг бүтээн битүү далд хадгалж, дэлгэрүүлээгүй бөгөөд анхны хувилбарын 1 хувь нь Парисын ШУА, 2 дох хувь нь Копенгагенд хадгалагдаж буйг олж тогтоолоо.

Ном зүй:

1. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2016.
2. Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг. УБ, 1971.
3. Дагданбазар Б. Орчин үеийн биеийн бүтэц зүй судлалын хөгжилд монголын эмч, зодч нарын бүтээлийн үүргийг тодорхойлох асуудалд, Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ, 2002. х.15-16.

4. Дагданбазар Б. Орчин үеийн биеийн бүтэц зүй судлалын хөгжилд монголын эмч, зодч нарын бүтээлийн үүргийг тодорхойлох асуудалд, Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ, 2002. х.3-4.

5. Жонатан Д.Спэнс. Энх-Амгалан хаан. УБ, 2015. х.135.

6. T.Kue-Hing Youg, MD, Regina, Sask. French Jesuits and the “Manchu Anatomy” how missed the Vesalian Revolution. CMAJ•JAMC.1974 Sep21; 111(6):565-568. PubMed

7. Зарлигаар тогтоосон Хэ-Ти-Чиуван-Лубичиг.Балдан-Очир, хян.ӨМШУТМХ, 1986

8. Жанжаа Агваанчойдонбалсамбуу. Аврал одуулахын хөтөлбөр бичиг. Булган Т, орч. УБ, 2017.

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
АУ-ы доктор Х.Туул*